



Үхлийн чанадад орших найдлага

Ирээдүйд Бүтээгч Эзэн мөхсөн бүтээлээ санаад үхэгсдийн орноос дуудан амилуулах болно. Эрт дээр цагаас эхлэн Бүтээгч Эзэнтэй алхдаг хүмүүс үүнийг мэддэг байв. Аврагч Эзэн төлөөсийг нь төлөн, хүн төрөлхтөнийг гэм ба үхлийн боолчлолоос чөлөөлөх болохыг

Иов ч мэдсэн. Христийн загалмайн тухай нарийн мэдлэг байгаагүй ч гэсэн, Аврагч Эзэн биеэрээ энэ дэлхийд ирэх тухай ойлголт эхнээс байсан. Энэ бүхнийг бид өмнөх нийтлэлээс олж харсан.

Өнөөдөр бид Аврагч Эзэнийхээ тухай илүү их мэдээлэлтэй. Тэрээр үхээд дахин амилахдаа бүтээлийнхээ манлайлагч болсон үнэнийг бид энэ нийтлэлд авч үзэх болно. Улмаар, Аврагч Эзэн нь амьд гэсэн бат итгэл Иовд хэрхэн тэсвэрлэх хүч чадал хайрлаж, бидэнд ч гэсэн ямар найдлага өгөхийг авч үзнэ.

Иовын тэсвэр тэвчээрийн нууц

Өөрийг нь өмгөөлөх, бас дахин амилуулах Аврагч Эзэнийг тэнгэрт байгааг, өөрөөр хэлбэл тэнгэрээс ирэх ёстойг Иов мэдсэн. Тухайлбал (Иов 16:19):

**“Одоо ч гэсэн Гэрч минь тэнгэрт байна.
Өмгөөлөгч минь өндөрт дээр байна...”**

Есүс Христ өнөөдөр үнэхээр тэнгэрт байна. Тэрээр Бүтээгч Эзэнд “ойртогсдыг бүрмөсөн аварч чадна.




Тэр тэдний төлөө зуучлан залбирч, үргэлж амьд оршдог” нь баттай (Еврей 7:25).

Иов лав Их Эзэнийг “нулимсаа урсган” харж, “анд нөхрөө өмөөрөх мэт Ертөнцийн Эзэний өмнө намайг тэр өмгөөлөөсэй” хэмээн санаа алдав (Иов 16:21; ББ).

Иовын сэтгэл үнэхээрийн хүнд байсан учраас тэр. Хамаг юмаа алдсныхаа дараа өөрөө аймшигтай өвчин туссан. Эхнэр нь түшиг болохын оронд “Ертөнцийн Эзэнийг хараагаад үх” гэж мунхаглаж орхив. Найзууд нь түүнийг ойлгож тайвшруулж өгөхийн оронд шүүмжлэл буруутгалаар дайрав.



Иовд түүний байдал үнэхээр гомдмоор байлаа. Хамгийн хэцүү нь ийм аймшгийн шийтгэл хүртэхээр буруу юм юу ч хийгээгүйг нь мэдэх ёстой Их Эзэн хүртэл өөрийнх нь эсрэг байгаа юм шиг түүнд санагдав. Бүхий л хичит Эзэн л өөрийг нь буруутгах мэт, эд хөрөнгийг нь сүйтгэж, амьдралыг нь бусниулсан нь яриангүй. Үндсээрээ сугарсан мод шиг байх ёстой газраа алдаж, бүгдэд хаягдсан мэт Иов өөрөө өөртөө санагдав. Сэтгэл нь үнэхээрийн хэцүү, амьдрал ямар ч найдваргүй мэт харагдаж байхад Иов гэнэт нөгөө алтан үгээ хэллээ. Иовын итгэлийн тунхагийг сонсооч (Иов 19:25-27):



**“Миний Өмгөөлөгч амьд гэдгийг
би мэдэж байна!
Тэрбээр эцэст нь миний төлөө
шороон дээр зогсох болно.
Арьс минь илжирч унасан байлаа ч
Биеэрээ [еврей: махбодоороо] би Бурханыг
[еврей: Элоааг]¹ үзэх л болно.
Өөр хэнийг ч бус Түүнийг л би харна.
Өөрийнхөө нүдээр би харна.”**



Иов хүнд хэцүү нөхцөл байдлынхаа дундаас Их Эзэнд итгэлтэй хэвээрээгээ зарласан. Сэтгэлийг нь унагааж байсан хүмүүсийн өөдөөс Иов Аврагчийнхаа амьд гэдгийг мэдэж байснаа баталсан. “Хэдийгээр амин сүнс минь надаас гарч, өт хорхой махбодийг минь идсэн ч гэсэн, амиллын

өглөө би Аврагчийнхаа царайг өөрийн биеэрээ харах л болно” гэсэн нь түүний найдлага.

1 “Эло-аа” гэдэг нь “Эл-тийш” буюу “Бурхан-луу-заагч” гэсэн утгатай нэр. Энэ нь Ертөнцийн Эзэний дүр төрх болж Түүнийг илчлэн заадаг Есүс Христийг хэлнэ (Холоссай 1:15). Есүс бол эхэнд байсан Ертөнцийн Эзэний Логос буюу Үг байсан бөгөөд “Логос нь Бурхан лугаа асан” (Иохан 1:1, 1846; АБ: “Үг Бурхантай хамт байсан”; грек: “Үг Бурхан луу байсан”).

Ертөнцийн Эзэн Эцэг Өөрөө Сүнс учраас хэн ч Түүнийг харж чадахгүй (Иохан 4:24; 1:18). Элоаа гэдэг нэр «Хуучин гэрээ»-нд 57 удаа гардаг бөгөөд эдгээрээс 41 нь «Иов» номд бий. Ингээд «Иов» ном бүхлээрээ Христ Өмгөөлөгчийг заадаг юм.



Найдваргүй энэ баргар байдлаараа нас барахад хүрсэн ч хамаагүй, Аврагчтайгаа нүүр тулан уулзахаа лавтайяа мэдсэн. Аврагч нь өөрийг нь нас барсан ч гэсэн үхлээс ч гаргана гэдэгт бат итгэсэн. Үхлийн чанадад ч орших найдлага Иовд байлаа.

Яг энэ итгэл найдлага Иовыг хамгийн хэцүү үед нь хүртэл авч яваад найдварын хамт тэсэх чадал



хайрласан. Хоёр мянгаад жилийн дараа Иовын тэсвэр тэвчээр итгэгчдийн үлгэр дуурайл болж мөнхөрчээ (Иаков 5:11). Иовын зовлон бүрийг тэсвэрлэж чадсан нууц нь энэ итгэлд нь оршив. Амьдрал нь яагаад сүйрч байгааг Иов ойлгосонгүй. Их Эзэн, Сатан хоёр итгэлийг нь сорьж шалгахаар тохирсон гэдгийг мэдэх арга түүнд байсангүй. Итгэлийг сорих зовлонг хэрхэн туулсан түүх нь олон мянган жилийн дараа ч үй түмэн хүнд урам зориг хайрлана гэдгийг гадарлаа ч үгүй. Буруу юм хийгээгүй боловч дэндүү их зовж буйгаа л Иов сайн мэдсэн. Тэгсэн ч гэсэн Их Эзэнд итгэлээ тавьдаг хэвээрээ. Аврагч нь заавал ирнэ гэж өөртөө сануулсаар байжээ.

Итгэлээ шалгуулах зовлонг туулсны үр дүнд Иов Ертөнцийг бүтээгч Эзэн чухам Хэн болохыг илүү сайн ойлгон авч, хамаагүй ойр харилцахад хүрсэн юм. Шуурган дундаас Бүтээгч Эзэн түүнд үгээ



хэлсний дараа Иов хариуд нь: "Таны тухай чихээрээ сонсож л байлаа, би. Тэгтэл одоо нүд минь Таныг харж байна" гэжээ (42:5; АБ). Их Эзэн зүрх сэтгэлийнх нь харааг нээсэн билээ. Ингээд Иовын хүлээлт анхны биеллээ оллоо. Үр дүнд нь үхлийн чанадах найдлага нь улам хүчтэй болсон нь лавтай.

Есүс гэм ба үхлийн асуудлыг шийдсэн нь

Иовыг өмгөөлөх буюу зольж авах Аврагч нь “Есүс” гэдэг нэртэй болохыг бид өнөөдөр мэднэ. Есүс Их Эзэн бол “Бурхан ба хүмүүсийн хоороондох ганц зууч” мөн (1 Тимот 2:5). Ганц биш, хоёр удаа энэ дэлхий дээр ирэх ёстойг нь бид өнөөдөр мөн мэдсэн. Анх ирэхдээ Есүс Эзэн амиа загалмай дээр өргөл болгон өргөж, гэм ба үхлээс чөлөөлөх төлөөсийг төлжээ (Иохан 10:10-11, 17-18). Энэ Өргөлөөрөө Тэрээр орчлон ертөнцийн гэмийг зайлуулсан бөгөөд үхлийн асуудлыг нэгмөсөн шийдсэн юм (Иохан 1:29).



Энэ бол Түүний эхнээс нь хүлээсэн үүрэг байлаа. Учир нь, **“Түүн дотор тэнгэр ба газар дахь бүх юмс... бүтээгдсэн. Бүх юмс Түүгээр болон Түүний төлөө бүтээгдсэн”** (Колоссай 1:16). Хамаг бүтээлийг хариуцдаг эзний хувьд Ертөнцийн Эзэний Хүү аврагч нь болох учиртай.



Эрт дээр үеэс төлөвлөсөн авралын ажлынхаа талаар Их Эзэн эртний өвөг эцгүүдэд ярьсан байж.

Хачирхалтай нь, Адам бол Христийг дүрсэлдэг үлгэр загвар гэдэг (Ром 5:14). Яагаад тэр вэ? Адам анхны хүний хувьд бүх хүн төрөлхтөний өвөг эцэг буюу тэргүүн нь болжээ. Үр удмаар нь төрсөн бид бүгд нэг ёсондоо “Адамын дотор бүтээгджээ”. Адамыг анхны гэм хийх үед бид бүгд “түүний дотор” байсан учраас бүгд түүнд оноогдсон үхлийн ялыг авцгаасан билээ.

Яг үүнчлэн Адамыг бий болохоос ч өмнө бүх орчлон ертөнц “Христийн дотор бүтээгдсэн” юм. Хамаг ертөнц Түүнээс үүдэлтэй, улмаар одоо ч “Бүх юмс Түүний дотор оршин тогтнодог” (Колоссай 1:17; АБ2004). “Бүх юмс” Христийг нас барах үед ч гэсэн “Христийн дотор” байсанд тооцогдох учраас бүхий л орчлон ертөнц Түүний хамт тэр загалмай дээр нас барсанд ч тооцогдоно. **“Нэг нь бүх хүмүүсийн төлөө үхсэн тул бүгд үхсэн”** гэдэг нь тийм учиртай (2 Коринт 5:14).

Дахин хэлэхэд, Адамын анхны гэмээс болж хүн бүр нас барах тавилантай болсон шиг Христийн загалмайн дээрх үхлээс болж хүн төрөлхтөн зогсохгүй,





хуучин бүтээл нь тэр чигтээ нас барсанд тооцогддог. Христийн үхлээс хойш Бүтээгч Эзэний хувьд **“Хуучин юмс нь [=бүтээл] өнгөрчээ”** (2 Коринт 5:17). Мэдээж, төрөх ёстой бүх хүнд Адамын ял буухын тулд олон мянган жил шаардлагатай бөгөөд энэ үйл явц өдий хүртэл дуусаагүй байна. Үүнчлэн, Христийн загалмай бүх бүтээлд хүрэхийн тулд тэр бүтээл нь эхлээд бүрэн өрнөн дэлгэрэх ёстой. “Тэнгэр үгүй болох” хүртэл тэнгэр ба газар дэлхий “хувцас адил элэгдэх” болно (Иов 14:12; Еврей 1:10-12).

Гэтэл хуучин бүтээл мөхөх нь энэ ертөнцийн төгсгөл биш. Бүтээгч Эзэн “мутрынхаа бүтээл рүү тэмүүлэх болно” шүү дээ (Иов 14:15)! Христ амиа өгөөд үхсэн ч гэсэн, хэзээ ч гэм ба үхлийн “ялзралын боолчлол”-д байгаагүй учраас үхэлд баригдсаар байх нь боломжгүй учраас дахин амилсан (Үйлс 2:24)! Түүний дотор бүтээгдсэн хамаг ертөнц “ялзралын боолчлолоос чөлөөлөгдөх” найдлагатай (Ром 8:21). Сөнөсөн ч заавал шинээр бүтээгдэх ёстой (Илчлэл 21:1). Хүн төрөлхтөн ч гэсэн дахин амилаад зогсохгүй, шинээр бүтээгдэх учиртай. Бичвэрүүд энэ явдлыг ваарчины жишээгээр дүрсэлдэг. Ваарчин хүрдэн дугуйн дээр бүтэлгүйтсэн ваараа эвдлээд тэр л шавраар өөрийн дураар шинэ ваар урладаг (Иеремиа 18:3-4).





Үүнчлэн Агуу Ваарчин мөхлийн боолчлолд баригдсан анхны бүтээлээ нураагаад шинээр бүтээх болно. “Ваарчин хэзээ ч шавраа зүгээр хаяж устгадаггүй” гэж нэгэн ваарчин эргэцүүлэн хэлжээ.

Бичвэрүүд хүн төрөлхтөн шинээр бүтээгдэх талаар олонтаа дурддаг. Үүнд: **“Адам дотор бүгд үхдэгчлэн Христ дотор бүгд амьд болгогдох болно. Харин тус бүр өөрийн дараалалтай байна...”** (1 Коринт 15:22-23).

“Бүгд үхдэг” гэсэн нь бид бүгд өдрөөс өдөрт доройтон үхсээр байдаг явцийг хэлнэ. Харин “амьд болгогдсон” хүн төрөлхтөн, бүтэлгүйтэхэд хүргэсэн үхлийн ялзралаас ангид амьтай байх учиртай.

Үхлийн асуудал шийдэгдэхээр гэм нүглийн асуудал ч шийдэгдэхийг Иов эрт дээр үед ч гадарласан билээ (Иов 14:13-17). Иймд “амьд болгогдох” нь цагаатгагдаж зөвт хүн болохтой нягт холбоотой. Хүний дотор явагдаж буй үхэл амийн хүчийг нь доройтуулдгийн улмаас бүгд яалт ч үгүй гэм хийдэг тухай бид өмнөх нэг нийтлэлээс олж харсан. Харин хүн төрөлхтөнийг “амьд болгогдох” үед үхэл хатгуурынхаа хамт үгүй болно (1 Коринт 15:55-56). Үр дүнд нь бүгд гэм хийлгүй зөв шударга байх болно. Үүнийг ч Бичвэрүүд олонтаа хэлдэг.

Тухайлбал:

“Бүгд нүгэл үйлдсэн тул Бурханы алдар сууд хүрдэггүй авч Христ Есүсийн золилтоор дамжин Бурханы нигүүлслээр үнэгүй зөвтгөгдөнө...” (Ром 3:23-24).




Адамаас болж өөрийн эрхгүй “нүгэлтэн болгогдсон” тэр тоо томшгүй олон хүн Есүс Христийн загалмайн ачаар “зөвт болгогдох” цаг ирнэ (Ром 5:18-19). Адам гэм ба үхлээр бүтэлгүйтэж буй хүн төрөлхтөний тэргүүн болсон бол Христ үхэшгүй амьтай, гэмгүй шинэ бүтээлийн Тэргүүн болох учиртай. Үхэл ба гэм анхны хүнээр орж ирсэн билээ. Үүнчлэн, үхэшгүй амь ба зөв шударга байдал “хоёрдахь хүн” болох бидний Их Эзэн Есүс Христээр дамжин орж ирэх ёстой (1 Коринт 15:47).



Тэр шинэ бүтээлийн эхлэл хэдийнэ тавигдсан. Эхлэл ба үндэс нь дахин амилсан Есүс Христ Өөрөө. Адам хуучин хүн төрөлхтөний тэргүүн байсан бол Есүс шинэ хүн төрөлхтөний Тэргүүн болжээ. Түүнд итгэсэн хүмүүс өнөөдөр ч сүнсээрээ Түүнтэй нэгдэж, тэр шинэ бүтээлд нь хамрагдсан (2 Коринт 5:17).

Одоогийн байдлаар сүнсээрээ л шинэ бүтээл болсон бид махбодоороо хуучин бүтээлийн “ялзралын боолчлол”-д хамрагдсан хэвээр бөгөөд “биеийг маань золин аврахыг тэсэж ядан хүлээдэг” (Ром 8:20-23).

Тиймээ, “тэнгэрээс ирэх Аврагч Эзэн Есүс Христийг бид тэсэж ядан хүлээж байна. Тэр бүх юмсыг Өөртөө захируулж чадах хүчээрээ дорд биеийг




маань Өөрийнхөө цог жажлант биетэй адил болгон өөрчилнө” (Филиппой 3:20-21).

“Хэрэв бид Түүний үхэлтэй адил байдалд холбогдсон юм бол, мэдээж Түүний амилалтай нь ч адил байдалд бас холбогдох” учраас тэр (Ром 6:5). Энэ бол Их Эзэний Үгийн бидэнд өгсөн агуу их найдлага маань.


Иовын найдлага бас бидний найдлага

“Миний Өмгөөлөгч амьд гэдгийг би МЭДЭЖ байна!” гэж Иов зүтгэсэн билээ. Ертөнцийн Эзэнд итгэх түүний итгэл үнэн “цаанаасаа мэдээд байгаа зүйл” байсан. Ертөнцийн Эзэний бичгээр тогтоосон хөдлөшгүй баримтууд дээр тулгуурладаг бидний итгэл мөн “зүрх сэтгэлийн мэдлэг” байх болно.

Иовын адил бид эрх мэдэлтэйеэ “Миний Аврагч амьд гэдгийг би МЭДЭЖ БАЙНА” гэж зарлах эрхтэй.



Энэ тунхаг ялангуяа Иов шиг хүнд хэцүү байдалд орсон цагт зөв. Өлсгөлөн, дайн дажин, байгалийн гамшиг, ядуурал, хүчирхийлэл, урвалт зэрэг янз бүрийн хүнд байдалд итгэгч хүмүүс бусдын адил орох нь бий. Бусдын адил махбодоороо “ялзралын боолчлол”-д хамрагдсан хэвээрээ учраас тэр.



Үзэж буй зовлон үхэн үхтлээ үргэлжилж магадгүй. Энэ нь мэдээж хүсүүштэй зүйл биш. Гэтэл зовлон бэрхшээлд орох нь бас сайн талтай болохыг бид Иовын адил олж харна. Зовлон бэрхшээлд орох нь тэсвэр тэвчээрийг бий болгодог. Тэсч тэсвэрлэх нь бидний итгэлийг соригдон шалгуулсан болохыг харуулна. Улмаар, тийм шалгарсан итгэлтэй хүний найдлага зүрх сэтгэлд нь бат бөх сууна. Үхлийн чанадад орших найдлага Иовоос ч илүү бидэнд байх ёстой. Тийм найдлагатай хүн зовлонтойдоо гутрах биш харин ч баярлан явж чадна (Ром 5:3-5). Аврагч маань амьд учраас бүх юм эцэст нь сайхан болно гэсэн найдлага маань тэртэй тэргүй талаар өнгөрөхгүй юм.

Харанхуй үед Их Эзэний Үг замыг минь гэрэлтүүлэгч гэрэл (Дуулал 119:105). Их Эзэн биднээс үнэнч хайраа салгаагүй, бидний төлөө зуучлан гуйдгийг бид хэцүү үедээ бүр ч баттай мэдэж авах болно. Баталгаа нь энэ:

“Хэн Бурханы сонгосон хүмүүсийг буруутгах вэ? Бурхан бол зөвтгөгч Нэгэн мөн. Ялладаг нь хэн юм бэ? Христ Есүс үхээд, бүр амилуулагдсан, Бурханы баруун талд буй агаад бидний төлөө зуучлан гуйдаг Нэгэн юм. Хэн биднийг Христийн хайраас салгах юм бэ? Гамшиг уу, шахалт уу, хавчлага уу, өлсгөлөн үү, нүцгэрэл үү, аюул уу, илд үү? ... Үхэл ч, амь ч,” юу ч “Бурханы хайраас биднийг салгаж чадахгүй гэдэгт би бат итгэлтэй байна” (Ром 8:27-28,33-35,39).



Хэрэв Бурхан бидний талд юм бол,
хэн биднийг эсэргүүцэх вэ?


--Ром 8:31



Дээрх үгийн үнэнг мэддэг итгэл биднийг хамгийн хэцүү сорилтын дунд ч гэсэн авч явж, урагшаа алхах хүч чадал хайрлах болно. “ХЭНД итгэснээ МЭДДЭГ” юм бол зовлонд орохдоо ямар ч байсан ичиж зовох хэрэггүй (2 Тимот 1:12).

“Зүрхний мэлмий” нээгдсэн бид Аврагчаа “цовдлогдсон боловч Бурханы хүчээр амьд” бөгөөд “бид мөн...Бурханы хүчээр Түүний хамт амьд байх болно” гэж Иовын адил мэднэ (2 Коринт 13:4; Эфес 1:18).

Үнэхээр Есүс Христ тогтоосон нэгэн өдөр тэнгэрээс буун ирж, Христийн Биед хамрагддаг үхсэн, үхээгүй бүх итгэгчийг Өөртөө авна гэж амласан (1 Тесалоник 4:13-17). Энэ дэлхийн боолчлолоос биднийг зольж авах төлөөсийг Тэрээр аль хэдийнэ төлсөн.



Бүх хэцүү байдлаас биднийг авран чөлөөлөх тэр өдөр улам айсуй. Энэ учралыг баяртайгаар угтаж чадахын тулд бид янз бүрийн гавъяа бүтээх шаардлагагүй. Иов шиг л итгэлээс тавилгүй тэвчин тэсвэрлэх нь хангалттай (2 Тимот 2:12).

Аврагчийнхаа амьд болохыг сэтгэлийн гүнд мэддэг хүн хичнээн агуу найдлагатай вэ! Бүтээгч Эзэнээ МЭДДЭГ хүмүүс юутай ерөөлтэй вэ! □

“Адам дотор бүгд үхдэгчлэн Христ дотор бүгд амьд болгогдох болно. Харин тус бүр өөрийн дараалалтай байна...” Энд ямар дараалалын тухай ярьж байгаа вэ? Энэ талаар дараагийн нийтлэлдээ авч үзэх болно.

Ашигласан эх сурвалж

---Ариун Библи (2004; 2013; 2019). Улаанбаатар: Ариун Бичээс Нийгэмлэг. Энэ судалгаанд АБ гэж товчилсон. Өөрөөр тодорхойлоогүй бол «Шинэ гэрээ»-ний ишлэлийг энэ орчуулгаас авсан байх болно.

---Библи (2015). Улаанбаатар: Монголын Библийн Нийгэмлэг. Энэ судалгаанд ББ гэж товчилсон.

---Сталлибрасс ба Своны «Шинэ гэрээ»-ний орчуулга (1846). London: British and Foreign Bible Society. Энэ судалгаанд 1846 гэж товчилсон. <https://mongol.bible/1846bible/john/>

---Стандарт Монгол Орчуулгын апп (2023). Энэ судалгаанд СМО гэж товчилсон. Өөрөөр тодорхойлоогүй бол «Хуучин гэрээ»-ний ишлэлийг энэ орчуулгаас авсан байх болно.

---Strong, J. (1890). Strong's exhaustive concordance of the Bible (with Greek and Hebrew Lexicons). www.blueletterbible.org